Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр
тогтоолын хавсралт

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 23 Улаанбаатар хот

| **НЭГ. Товч танилцуулга** |
|---|
| Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/87 дугаартай тушаалаар байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г байгуулсан.<br>Байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны даргаар Криминалистикийн шинжилгээний хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэ-Очир, нарийн бичгийн даргаар Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэхүү, гишүүнээр Шүүх анагаах ухааны газрын мэргэшсэн шинжээч эмч, цагдаагийн хошууч Ө.Сарангэрэл, Бүртгэл, мэдээлэл технологийн хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Бадамсайхан, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Т.Төгөлдөр, Санхүү, хангамжийн газрын ахлах нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямжаргал, Эрдэм шинжилгээ, сургалт, хөгжүүлэлтийн төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Мөнгөнсүх нар томилогдон ажиллаж байна. |
| **ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар** |
| 2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: |

| Үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээ | Хэрэгжилт |
|---|---|
| Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | Шүүх шинжилгээний байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд хийх сургалт, соён гэгээрүүлэх ажлын санал гаргаж, байгууллагын Сургалт, Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулан төлөвлөгөөний дагуу ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.<br>Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын дунд эерэг харилцаа, зөв хандлагыг дэлгэрүүлж иргэд, байгууллага, хамт олонтойгоо ойлголцох, хамтран ажиллах итгэлцэл бий болгох зорилгоор “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Эерэг харилцаа, зөв хандлага”, "Ёс зүйг эрхэмлэе" нөлөөллийн аяныг батлагдсан удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулсан.<br>Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байх чиглэлээр “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”-г илэрхийлсэн богино хэмжээний видео контент бэлтгэсэн. |
| Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулна. | 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр “Шүүх шинжилгээний байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хийх ажлын төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Ёс зүйн тухай хууль, МУ-н Ёс зүйн хорооноос зохион байгуулж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ, бусад мэдээ мэдээллийг байгууллагын нийт алба хаагчдад мэдээлж танилцуулан, хийсэн ажлын тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Мөн ирүүлсэн өргөдөл гомдлыг хууль, журамд заасны дагуу хянан шалгаж, томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулан ажиллаж байна. |
| Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байх чиглэлээр “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”-г илэрхийлсэн богино хэмжээний видео контент, уриалга, |

| | |
|---|---|
| хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана. | мэдээлэл түгээх хуудсыг бэлтгэж, байгууллагын цахим хаягаар алба хаагчдад түгээсэн. |
| Нөлөөллийн мэдүүлэг гаргагчид авах арга хэмжээг байгууллага бүр хэрэгжүүлж, мэдээллийг олон нийтэд байршуулах замаар хариуцлагыг нэмэгдүүлэх | “Авлига албан тушаалын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг таслан зогсоох нөлөөллийн арга хэмжээ, авлигын эсрэг хууль тогтоомж” “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”, “Нөлөөллийн мэдүүлэг гаргах журам” сэдэвт сургалт тус тус зохион байгуулж алба хаагчдад “Ёс зүйн зөрчил, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” тухай баталгааны хуудсыг танилцуулан, 170 алба хаагчаас гарын үсэг зуруулж баталгаа авсан. Мөн МУ-н Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг”-ийг алба хаагчдад танилцуулан, ёс зүйн эрсдлийн үнэлгээ, хариу арга хэмжээний талаарх мэдээллийг авч нэгтгэн ажиллаж байна. |
| Ёс зүйн төлөвшил, зан үйлийн хэв маягийг тодорхойлох сорил, даалгаврын агуулгаар үнэлэх үйл ажиллагааг өргөжүүлэн, төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоонд тулгуурлан хөгжүүлнэ. | Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний талаарх санал, асуулгыг байгууллагын нийт алба хаагчдаас авч, судлан нэгтгэж, дүн шинжилгээ хийж ажилласан.<br>Судалгааны үр дүнд үндэслэн алба хаагчдад ёс зүйн сургалт зохион байгуулж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн, стресс менежментийг сайжруулах арга хэмжээ авч “Эерэг харилцаа, зөв хандлага”, “Сэтгэцийн эрүүл мэнд” аян, холбогдох сургалтуудыг тус тус зохион байгуулж “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”-г илэрхийлсэн богино хэмжээний видео контент бэлтгэж, байгууллагын цахим сайтад байршуулсан.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу гаргаж нэгтгэсэн. |
| Төрийн албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлнэ. | Ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэнээс ирүүлсэн 1, алба хаагчийн гаргасан 3 өргөдлийн дагуу зөрчлийг шалгаж байгууллагын Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэж, ёс зүйн зөрчил тогтоогдоогүй 3, ёс зүйн зөрчил тогтоогдсон 1 алба хаагчид ёс зүйн хорооны дүгнэлт гаргаж байгууллагын удирдлагад танилцуулсан. Төрийн албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлэх чиглэлээр байгууллагын Сургалт, Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг Ёс зүйн дэд хорооноос хариуцан зохион байгуулж, шинээр томилогдсон болон байгууллагын нийт алба хаагчдад сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. |
| Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, соёлыг хэвшүүлэх дагалдуулах, чиглүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэн, бэлтгэгдсэн багш нараар сургалт зохион байгуулах | Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Сэтгэцийн эрүүл мэнд” сэдэвт аяны хүрээнд Нийгэм судлалын дээд сургуулийн багш, магистр Д.Даваасүрэнг урьж “Сэтгэл заслын бясалгалын дасгал, сургалт”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр, Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, Анагаах ухааны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр М.Цэрэнбатыг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, сургагч багш Ч.Отгонбаярыг урьж “Харилцаа, хандлага, хүндлэл, хариуцлага” сэдэвт суррггалтыг тус тус зохион байгуулсан. |
| Төрийн өндөр, томилох эрх бүхий албан тушаалтны манлайлал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн төрийн залгамж чанарыг хадгалах, хөгжүүлэх, инновац шингээсэн ёс | |

| | |
|---|---|
| зүйн орчин нөхцөлийг бий болгох замаар хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах | |
| Төрийн албаны стандартыг мөрдүүлэх, төрийн албан хаагчийг ёс зүйн хандлагаар үнэлэх, хөгжүүлэх, бодлогыг хэрэгжүүлэх | Байгууллагын хэмжээнд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж “ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО-ШААРДЛАГА” стандартын магадлах-1 аудитад амжилттай хамрагдсан.<br>Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга гишүүд “ISO MIND” ХХК-ийн Ерөнхий зөвлөх Т.Бадамсэдийн ISO 9001:20158 ISO/IEC 1702552017 стандартын "Менежментийн тогтолцооны дотоод аудиторыг чадавхжуулах" сургалтад хамрагдаж сертификат авсан.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмарын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 3/1158 дүгаартай “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Ёс зүй хорооны 2025 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д тусгагдсан төрийн бүх шатны буюу өөрийн байгууллагад хамааран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд 2025 оны 08 дугаар сарын байдлаар гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дотор ирүүлэх” тухай албан бичгийг үндэслэн Шүүх шинжилгээний байгууллагад хамааран хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн.<br>Ёс зүй хорооны 2025 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д тусгагдсан өөрийн байгууллагад хамааран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 87.1 буюу бүрэн хангалттай гэж үнэлэгдсэн. |
| Төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн тусгай, төрийн улс төрийн албан тушаалтны өргөх тангарагийн хуудсанд ёс зүйг эрхэмлэн сахих талаар тусгах | Шүүх шинжилгээний тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д шинжилгээний байгууллагын алба хаагчийн тангарагийг тусгасан. Уг тангарагт алба хаагч ёс зүйг чанд сахих агуулга оруулсан. |
| Өргөсөн тангараа чандлан мөрдөх сэдэл, урам зориг, дадлыг бий болгоход чиглэсэн бүтээлч ажлыг идэвхжүүлэх, соёлыг түгээх, хэвшүүлэх | Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын дунд эерэг харилцаа, зөв хандлагыг дэлгэрүүлж иргэд, байгууллага, хамт олонтойгоо ойлголцох, хамтран ажиллах итгэлцэл бий болгох зорилгоор “Эерэг харилцаа, зөв хандлага” аяны удирдамжийн дагуу “Харилцааны ур чадвар ба хамт олны уур амьсгал” “Зөв хандлагын нөлөө ба ёс зүй” сэдвийн хүрээнд бүтээлч ажил, сургалт зохион байгуулсан. Тухайлбал сургагч багш Ч.Отгонбаярыг урьж “Харилцаа, хандлага, хүндлэл, хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байх чиглэлээр “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”-г илэрхийлсэн богино хэмжээний видео контент, уриалга, мэдээлэл түгээх хуудсыг бэлтгэж, байгууллагын цахим хаягаар алба хаагчдад түгээсэн. |
| Ажлын байран дахь ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын үр дүнг мэдээлэх. | Ёс зүйн дэд хорооны гишүүдэд “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” болон Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэсэн мэдээллийг хянах заавар, зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах зорилгоор зохион байгуулагдсан “Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах” сургалтад 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгууллагын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хамрагдсан.<br>Удирдлагын академиас зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалтад 2025 оны 11 дүгээр сарын 13, 2025 оны 12 |

| | |
|---|---|
| | дугаар сарын 06-ны өдрүүдэд Захиргаа удирдлагын газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Амар, 2025 оны 11 дүгээр сарын 14 өдөр Хүний нөөцийн хэлтсийн дарга, цагдаагийн ахмад Ө.Цэвээндорж, 11 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газрын дарга, цагдаагийн хурандаа У.Болдбаатар, чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Т.Нүрмаа, 12 дугаар сарын 04-ний өдөр дэд дарга, цагдаагийн хурандаа Э.Халиунбаяр нар хамрагдаж сертификат авсан.<br>Ёс зүйн дэд хорооны дарга, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэ-Очир байгууллагын нийт алба хаагчдад “Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа”, “Ёс зүйн тухай хууль”-ийн хэрэгжилт, үр дүнгийн талаар сургалт, танилцуулга мэдээлэл хийсэн.<br>Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, Анагаах ухааны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр М.Цэрэнбатын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад танхим болон цахимаар нийт 248 алба хаагчийг хамруулсан.<br>Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 28,29-ний өдүүдэд зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” нийслэлийн бүсийн зөвлөгөөн, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэгт тус төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Мөнгөнсүх оролцсон.<br>Баян-Өлгий аймгийн шүүх шинжилгээний хэлтсээс ахлах шинжээч эмч, цагдаагийн хошууч К.Хайратын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн сургалтад 9 алба хаагч, криминалистикийн ахлах шинжээч, цагдаагийн ахмад Р.Еркинжаны 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Төрийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сургалтад 8 алба хаагч хамрагдсан.<br>Шүүх шинжилгээний байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, Анагаах ухааны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр М.Цэрэнбатыг урьж, 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт, Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн багш, сэтгэл судлалын шинжлэх ухааны магистр, бэлтгэл хошууч Д.Даваасүрэнг урьж, 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Ажлын байрны сэтгэцийн эрүүл мэнд, харилцаа хандлага” сэдэвт сургалт, мөн “Эерэг харилцаа, зөв хандлага” аяны хүрээнд Амьдралд ойрхон харилцаа ТББ-ын сургагч багш Ч.Отгонбаярыг урьж, 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр “Эерэг харилцаа, зөв хандлага” сэдэвт сургалт, Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал" сэдэвт сургалтуудыг алба хаагчдад мэдээлж, цахимаар тус тус хамруулсан. Тус сургалтуудад давхардсан тоогоор 42 алба хаагч хамрагдсан байна.<br>“Эерэг харилцаа, зөв хандлага” аяны хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Насан туршийн суралцахуйн төвийн багш К.Ахтолхыныг урьж, алба хаагчдад “Хамт олны хандлага, харилцаа, ёс зүй” сэдвээр танхимын сургалт болон хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Ховд аймаг дахь Бүсийн Шүүх шинжилгээний төвөөс 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Ёс зүйг эрхэмлэе" аяны хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлэгт 10 албан амжилттай хамрагдсан.<br>Дорноговь аймгийн шүүх шинжилгээний хэлтсээс |

| | |
|---|---|
| | криминалистикийн шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч М.Цогтбаяр “Ёс зүйг эрхэмлэе” нөлөөллийн аяны хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдвээр сургалтуудаг тус тус зохион байгуулж ажилласан.<br>Бүртгэл, мэдээлэл, технологийн хэлтсээс “Эерэг харилцаа, Зөв хандлага” аяны хүрээнд хэлтсийн албаа хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Бадамсайхан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр сургалт зохион байгуулж мэдээлэл хийж ажилласан.<br>Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвөөс сэтгэл зүйч Б.Нарангарав Эерэг харилцаа, зөв хандлага сэдэвт нөлөөллийн аяны хүрээнд албаа хаагчдад “Харилцаа ба хандлага” сэдвээр танхимын сургалт зохион байгуулсан. Мөн сэдэвт Амьдралд ойрхон харилцаа ТББ-ын сургагч багш Ч.Отгонбаярын “Эерэг харилцаа, зөв хандлага” цахим сургалтад 2025.06.03-ны өдөр албан хаагчдыг бүрэн хамруулж мэдлэг мэдээллийг авч ажилласан.<br>Төвийн /Дорнод аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв/ цахим хуудсаар “Эерэг хандлагын зарчим” постерийг цахим хуудсанд байршуулж нийт 70 лайк, 26 шейр хийж олон нийтэд түгээн ажилласан.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэг олгох хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр төвийн албаа хаагчдын дунд амжилттай зохион байгуулсан.<br>Дорнод аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудыг нөлөөллийн аянд нэгдэхийг уриалж хууль хяналтын байгууллагын дунд байрлуулсан мэдээллийн лед дэлгэцээр аяны постерыг байршуулж бүх нийтэд түгээх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Албан хаагчид аяны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн нийтлэг хэм хэмжээний заалтыг таниулах 1 минутийн богино хэмжээний бичлэгийг бэлтгэж, төвийн цахим хуудсаар нийтэлж, нийт 34 лайк 12 шейр хийж олон нийтэд түгээн ажилласан.<br>Тус төвийн ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Э.Дэлгэрцэцэг, бүртгэлийн ажилтан, цагдаагийн дэслэгч Г.Сансар нараас “Эерэг бол гоё” сэдэвт нөлөөллийн аяныг санаачилан зохион байгуулж, албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, бусадтай ёс зүйтэй, хүндэтгэлтэй харьцах, ажлын байрны соёлыг түгээх арга хэмжээнд албан хаагчдыг уриалж оролцуулсан.<br>Албан хаагчдын ажлын өрөө бүрт зурагт хуудас бүхий сургамжит үгсийг байршуулсан.<br>“Өглөөг өөдрөг эхлүүлье” сэдвийн хүрээнд албан хаагчдын ажиллах эрч хүчийг нэмэгдүүлэх, эерэг харилцааг түгээх зорилгоор сонгосон зүйлийг бэлэглэж урамшуулах арга хэмжээг зохион байгуулсан.<br>“Хөгжилтэй өдөр” сэдвээр албаа хаагчдын дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, дасгал хөдөлгөөнийг орлуулах зорилгоор ажлын байранд хөгжөөнт тоглоомыг зохион байгуулж гарын бэлэг гардуулсан.<br>“Чин сэтгэлийн илгээмж” сэдвээр албан хаагчид бие биенийхээ сайн тал, үлгэр дуурайлал болсон зан чанарыг урамшуулан бичиж эерэг сэтгэл түгээх арга хэмжээг зохион байгуулсан.<br>“Цайны цагаараа-Зангиагүй уулзалт” сэдвээр албан хаагчдаас сонгон ажил үүрэг гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээ, санал, санаачилгын талаар богино хугацааны ганцаарчилсан уулзалтыг 4 албаа хаагчидтай зохион байгуулж тэдний санал, хүсэлтийг сонсож зөвлөгөө мэдээллийг өгсөн. |

| | |
|---|---|
| | Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвөөс “Нөлөөллийн контент” арга хэмжээний дагуу ШШЕГ-ын аяны хүрээнд хийгдсэн фэйсбүүк пэйж хуудсанд тавигдсан нөлөөллийн постуудыг говийн Бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн алба хаагчид хувийн фэйсбүүк цахим хаяг, байгууллагын цахим хаягаар тус тус шейр хийж түгээсэн. 2025.11.12-ны өдөр Говийн Бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн нийт алба хаагчдыг хамруулан ёс зүйн чиглэлээр цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” түүний хэрэгжилт, хамрах хүрээ, зорилго зорилтыг болон өдөр тутамд тулгамдаж буй ёс зүйн холбоотой асуудлуудыг, ёс зүйн зөрчлөөс урьдчилан хэрхэн сэргийлэх талаар хэлэлцсэн.<br>Соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээний дагуу 2025.11.13-ны өдөр Монголын Хуульчдын Холбооны Өмнөговь аймаг дахь салбарын зохицуулагч, Өмгөөлөгч Э.Дөлгөөнийг урьж, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Монгол улсын төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж Говийн Бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн нийт алба хаагчдыг хамруулсан.<br>2025 оны 04 дүгээр сарын 21,22-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд Монгол Улсын Их хурал, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас тус тус хамтран зохион байгуулагдсан Говийн бүсийн бүсчилсэн /Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь/ аймгуудын “Төрийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-нд тус төвийн дарга говийн бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн алба хаагчдын хамт оролцож, зөвлөгөөний үеэр УИХ-ын гишүүн, Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн нар “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалт зөвлөгөөнд Говийн Бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсийн дарга, алба хаагчид оролцсон.<br>Завхан аймгийн Шүүх шинжилгээний хэлтсээс “Ёс зүйг эрхэмлэе” нөлөөллийн аяны хүрээнд: Шүүх шинжилгээний ерөнхий газар, Ховд аймаг дахь бүсийн шүүх шинжилгээний төвөөс “Ёс зүйг эрхэмлэе” нөлөөллийн аяны хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын талаар алба хаагчдад танилцуулж, иргэд олон нийтэд түгээх зорилгоор Хэлтсийн Facebook болон алба хаагчдын хувийн Facebook дээр нийтлүүлж ажилласан. Мөн “Ёс зүйг эрхэмлэе” нөлөөллийн аянд, Завхан аймгийн шүүх шинжилгээний хэлтэс нэгдэж байна гэсэн постер олон нийтийн сүлжээнд нийтэлсэн.<br>Ховд аймаг дахь бүсийн шүүх шинжилгээний төвөөс 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Ёс зүйг эрхэмлэе" аяны хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлэгт 13 алба хамрагдсан болно.<br>ШШБ-ын дотоод журмыг албаны сургалт, бие даалтаар судлуулан, алба хаагч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэх арга хэмжээ авч ажилласан.<br>Хамт олны дунд эерэг сэтгэгдэл түгээх зорилгоор хамт олондоо хайр түгээх “надаас чамд-дараагийн хүндээ юу өгөх вэ” үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр тус тус зохион байгуулсан.<br>Санхүү, хангамжийн газрын алба хаагчид Дэлхийн Буддистуудын Дээд чуулганы ивээгч, Азийн Буддистуудын Энх тайвны Бага хурлын Ерөнхийлөгч, Энэтхэгийн Олон Улсын Бурханы Шашинтнуудын дээд зөвлөх, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Дэмбэрэлийн Чойжамцыг урьж, байгалиа хайрлах |

| | |
|---|---|
| | сэтгэлгээ, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, хүний эрхэм чанар, ёс суртахууны талаар лекцэд 2025.06.10-ны өдөр 8 алба хаагчид цахим, 4 алба хаагч танхимаар хамрагдсан.<br>Говь-Алтай аймгийн шүүх шинжилгээний хэлтсийн алба хаагчид Шүүх шинжилгээний байгууллагын 2025 оны “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний 2.2 дахь хэсэгт тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, алба хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамт олны дунд эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооноос “Ёс зүйг эрхэмлэе” нөлөөллийн аяны хүрээнд нөлөөллийн контентыг “Говь-Алтай Шүүх Шинжилгээний Хэлтэс” гэсэн Facebook хуудсанд богино хэмжээний бичлэг хийн байршуулж ажилласан.<br>Дархан-Уул аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвийн алба хаагчид Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний төв, хэлтсийн алба хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамт олны дунд эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор нөлөөллийн 3 контент, 9 фостер хийж нэгжийн фейсбүүк цахим хуудсаар бусдад түгээсэн.<br>"Ёс зүйг эрхэмлэе" нөлөөллийн аяны хүрээнд тус төвийн алба хаагчид 2025.11.12-нд "Canvas art" өдөрлөг зохион байгууллаа. Энэхүү өдөрлөг нь хамт олны харилцааг сайжруулах, өөрийгөө илэрхийлэх ба ёс суртахууны ухаарал, дотоод ухамсрыг төлөвшүүлэх, ажлын стресс бууруулах, байгууллагын соёлыг бэхжүүлэх ач тустай арга хэмжээг зохион байгуулсан. |
| Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн чиглүүлэх сургалтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх | Байгууллагад шинээр томилогдсон нийт 147 алба хаагчийг чиглүүлэх, ажлын байранд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Төрийн алба хаагчийн ёс зүй, хариуцлага, зохион байгуулалт, харилцааны соёл”, “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн төлөвшил” сэдэвт сургалт, байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн талаарх танилцуулгыг Ёс зүйн дэд хорооны дарга, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэ-Очир, гишүүн, цагдаагийн ахмад Б.Мөнгөнсүх, цагдаагийн ахмад Т.Төгөлдөр нар тухай бүр зохион байгуулан ажиллаж байна |
| Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвөлгөө өгөх, зөрчлийг мэдээлэх зэрэг чиглэлээр нөлөөллийн аяныг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулан үр дүнг тооцох. | Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын дунд эерэг харилцаа, зөв хандлагыг дэлгэрүүлж иргэд, байгууллага, хамт олонтойгоо ойлголцох, хамтран ажиллах итгэлцэл бий болгох зорилгоор алба хаагчдад ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн, стресс менежментийг сайжруулах арга хэмжээ авч “Эерэг харилцаа, зөв хандлага”, “Сэтгэцийн эрүүл мэнд” зэрэг аян зохион байгуулж, дээр дурдсан холбогдох сургалтуудыг тус тус зохион байгуулж “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”-г илэрхийлсэн богино хэмжээний видео контент, уриалга, мэдээлэл түгээх хуудсыг бэлтгэж, байгууллагын цахим хаягаар алба хаагчдад түгээсэн.<br>“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.3.4 дэх заалт, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар зорилгын 2.1, Шүүх шинжилгээний байгууллагын 2025 оны “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 2.2 дахь хэсэгт тусгасан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Ёс зүйг эрхэмлэе" нөлөөллийн аяныг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс энэ оны 11 дүгээр сарын 14-ний хооронд амжилттай зохион байгууллаа. |

| | |
|---|---|
| | Уг аяны хүрээнд Шүүх шинжилгээний байгууллагын ёс зүйн зөвлөгөөнийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, мөс хагалах дасгал, сэтгэл зүйн дасгал, кейст суурилсан хэлэлцүүлэг өрнүүлсэн. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг үнэлэх ажлыг зохион байгуулж, манлайлж оролцсон Ховд аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвийг батламж, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.<br>2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын холбоонд зохион байгуулагдсан Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резидентийн хөтөлбөрт бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээг сэдэвчлэн оруулах талаарх уулзалт ярилцлага, 2025 оны 03 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбооноос зохион байгуулагдсан “Бэлгийн хүрчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ” сэдэвт төгсөлтийн дараах хөтөлбөрийн сургагч багшийн сургалт, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аливаа гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт тус тус ёс зүйн дэд хорооны гишүүн, цагдаагийн дэд хурандаа Ө.Сарангэрэл оролцож сургалт зохион байгуулж ажилласан. 2025.05.14-ны өдөр ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн төгсөх дамжааны сонсогч нарт "Хүүхдийн бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдсэн гэмт хэрэгт хохирогч төвтэй ажиллах аргачлал" сэдвээр сургалт зохион байгуулах, Цагдаагийн сургуулийн мөрдөх алба хөтөлбөрт үнэлгээ хийж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, цаг сэдвийн төлөвлөгөөнд дээрх сэдвийг оруулах, багш нарыг сургагч багшаар бэлтгэж, сертификат олгох зорилгоор ШШЕГ, НҮБ-ын Монгол дахь Хүн амын сангийн тэргүүн Халид Шарифи, ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн холбогдох төлөөллийн хамт хийсэн уулзалт, 2025.05.15-ны өдөр Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн ажиллагаанд оролцогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, хохирогч болсон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр ажиллах төлөвлөгөөний ажлын хэсгийн хуралдаанд ёс зүйн дэд хорооны гишүүн, цагдаагийн дэд хурандаа Ө.Сарангэрэл оролцов. |
| Ёс зүйн хариуцлагын бүртгэлийн цахим системийг нэвтрүүлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах | Алба хаагчдын гэмт хэрэг, захиргааны зөрчил, шийтгэлийн мэдээллийг Хүний нөөцийн хэлтсээс “Шүүх шинжилгээний нэгдсэн систем”-д тухай бүр бүртгэн ажиллаж байна. Байгууллагын Ёс дэд хорооны нарийн бичгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэхүү дэд хорооны хийсэн ажлын тайлан мэдээ, хянан шалгасан ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр Монгол Улсын Ёс зүйн хорооны цахим системд бүртгэн ажиллаж байна. |
| 2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал: | |
| Байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дэмжиж, ёс зүйн манлайлалтай ажилласан. | |
| 2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа: | |
| Ёс зүйн дэд хороон нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Шүүх шинжилгээний байгууллагын 2025 оны “Сургалтын төлөвлөгөө”, Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, Ёс зүйн дэд хорооны 2025 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл |
|---|---|
| Алба хаагчийн ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажил арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан. Алба хаагчдын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай мэдлэг нэмэгдсэн, ёс зүйг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгж дээр ажил арга хэмжээг зохион байгуулж тайлагнадаг. Алба хаагчид ёс зүйн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил, хэрэгжиж буй хууль тогтоомжийн талаар мэдээлэл авдаг. | Үндсэн ажлаас гадна хавсарч гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг тул төлөвлөгөөний дагуу гишүүд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тасралтгүй, сайн хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаартай “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар гарсантай холбоотой Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал олгогдоогүй. |
| Санал: | |
| 1. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг тогтвортой олгох<br>2. Ёс зүйн хорооноос төрийн байгууллагад хийх сургалтыг нэмэгдүүлэх<br>3. Ёс зүйн зөрчлийг хянан, шалгах арга ажиллагааны талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх | |

**Шалгах хэсэг:**

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ДОКТОР (Ph.D),
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ДАВАА

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ЭРДЭНЭ-ОЧИР

АБДХАГ-ЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.ЭРДЭНЭХҮҮ

Ёс зүн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
# “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

2025 оны 12 дугаар сарын 16 Улаанбаатар хот

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо | Хувийн жин |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх | | 1 | 1 | 100 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх | | 1 | 1 | 100 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сургийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батландсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх | 0.5 | 0.5 | 100 |
| | | | Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал | 0.5 | 0.5 | 100 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал | 0.5 | 0.5 | 100 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал | 0.5 | 0.5 | 100 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | **4** | 100 |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх | | 1 | 0.5 | 50 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал | | 1 | 1 | 100 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 1 | 100 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **2.5** | 80 |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал | | 1 | 1 | 100 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 1 | 100 |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал | | 1 | 1 | 100 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | 3 | 100 |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | | **10** | **9.5** | 95 |

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ЭРДЭНЭ-ОЧИР

# ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

оны 01 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

| Хийх ажил | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| Алба хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах | Тухай бүр | Дарга, Нарийн бичгийн дарга, гишүүд | Алба хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гарган удирдлагад танилцуулсан байна. |
| Алба хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл болон ажлын тайлан гаргаж, Ёс зүйн хороонд хүргүүлэх | Тухай бүр | Дарга, Нарийн бичгийн дарга | Ёс зүйн дэд хорооны тайлан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. |
| Алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг Ёс зүйн дэд хорооны “Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-нд туссаны дагуу зохион байгуулах | Тухай бүр | Дарга, Нарийн бичгийн дарга, гишүүд | Холбогдох нэгж, албан тушаалтантай хамтран алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. |
| Алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг Ёс зүйн дэд хорооны “Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-нд туссаны дагуу зохион байгуулах | Тухай бүр | Дарга, Нарийн бичгийн дарга, гишүүд | Холбогдох нэгж, албан тушаалтантай хамтран алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна. |
| Алба хаагчдаас ёс зүйн зөрчлөөс ангид байх талаар баталгаа авах | Тухай бүр | д/х Б.Эрдэнэхүү Гишүүд | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хариуцлагажуулсан байна. |
| Алба хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж тайлан, мэдээг байгууллагын ёс зүйн дэд хороонд ирүүлэх | Улирал бүр | Газар, төв, хэлтсийн дарга нар | Байгууллагын хэмжээнд ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдын ёс зүйн мэдлэг дээшилсэн байна. |

----o0o----